

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГАТАЙ
2018 ОНД БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2018 оны 06 дугаар сар 05

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Суурь түвшин	2018 онд хүрэх үр дүн	Хүрсэн үр дүн	Хувь
МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР					
1	Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан сум, аймгийн салбарын нэгжийн бүтэц, орон тооны өөрчлөлтийг ХХААХҮ-ийн сайдтай зөвшөлцөн мэргэжил арга зүйн зөвлөмжийн дагуу оновчтой хийх.	Сумын Засаг даргын тамгын газрын Мал эмнэлэг үржлийн тасаг, аймгийн ХХААГ-ын одоогийн бүтэц орон тоо	Хуулиудыг дагаж гарах Засгийн газрын шийдвэр хэрэгжсэн байна.	Шинээр гарсан малын генетик нөөцийн тухай хууль, Малын эрүүл мэндийн тухай хуулийг нийт 300 орчим малчид иргэдэд хүргэсэн. 6 сарын 1-ээс эхлэн батлагдсан бүтэц орон тооны дагуу аймагт Мал эмнэлгийн газар, сумдад Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлэгийн тасгийг ажиллуулна.	40
2	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах, аймаг сумын өвч, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулах.	Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар-ын дагуу 10 сарын 25-нд бэлтгэл хүлээж авхад 84,8 хувьтай хангасан дүн гарсан бөгөөд үүнээс ЗГ-ын 186 дугаар тогтоолоор өгсөн аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөцийн бүрдүүлэлт 80,3 хувьтай хангасан байсан. Төсвийн тодотголоор олгосон 169,3 сая төгрөгөөр өвс, тэжээл худалдан	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажилласан байна.	Хугацаа болоогүй.	-

		авч 98,0 хувь болгосон байна.			
3	2010 онд Улсын төсвийн хөрөнгөөр малжуулсан хөрөнгийн эргэн төвлөрүүлэлтийн тайлан, мэдээ ирүүлэх	Малжуулсан ажлын 2016 оны байдлаар 80,6 сая төгрөгийн эргэн төлөлт хийсэн 98,8 хувьтай сайн ажиллаж байна.	2017 оны байдлаар малжуулах ажлын тайланг 2018 оны 6 сарын 1-ны дотор ирүүлэх.	Засгийн газрын 2010 оны 197 дугаар тогтоолын дагуу 2017 оны эцсийн байдлаар Сайнцагаан, Сайхан-Овоо, Дэрэн, Дэлгэрхангай 4 сумын 48 малчин өрхийг 81.6 сая төгрөгөөр малжуулах төсөлд хамруулж эргэн төлөлт 99.2%-тай хэрэгжиж тайланг ХХААХҮЯамны МААБХЗГазарт хугацаанд нь хүргүүлсэн.	100
4	Аймаг дундын отрын бүс нутагт өвөлжүүлэх малыг мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамруулан, баталгаажуулж оруулах ажлыг зохион байгуулах.	Өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийгдээгүй мал олноор орж байна.	Отрын бүс нутагт орох малыг мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамруулж баталгаажуулсан байна.	Малын эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, гарал үслийг тодорхойлох, малын эрүүл мэндийн дэвтрийг шалгах, тарилга мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдаагүй бол отор нүүдэл хийлгэхгүй байх арга хэмжээ авч малчдад мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.	40
5	Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх тал дээр анхаарч иргэд аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сүүний үхэр, махны үхэр, гахай, шувуу, зөгийн бүлийн тоог урьд оноос нэмэгдүүлсэн байх.	2017 оны жилийн эцсийн тоогоор мах, сүүний үхэр 527 толгой, гахай 374, шувуу 623 байна.	Өмнөх оны эрчимжсэн мал аж ахуйн тоог 10 %-иар нэмэгдүүлэх, тайланг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэх	ХХААГазрын дарга, сумдын засаг даргын 2018 оны үр дүнгийн гэрээнд тус заалтын талаар тусган бодлогоор нэмэгдүүлэх боломжийг ханган ажиллаж байна. Сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг болон эрхлэх сонирхолтой 5 иргэнийг сүүний үхрийн аж ахуйн 7 хоногийн вакумжуулсан сургалтанд хамруулсан.	40
6	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг шинээр барих	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 2 худаг шинээр барьж ашиглалтанд оруулсан.	Улсын төсөв, гадаадын төсөл хөтөлбөр болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн усан хангамжийн зориулалттай инженерийн хийцтэй худгийн тоо 7-аас доошгүй нэмэгдсэн байх.	2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 гүн өрмийн худгийг нэр бүхий 6 суманд, худгийн өрөмдлөгийн машиныг гэрээгээр эзэмшигч Элбэгсанчир ХХК нь 10 суманд 11 гүн өрмийн худгийг гаргах гэрээг байгуулаад ажил эхэлж байна. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 17 худаг гаргана. Сумдууд энгийн уурхайн худгуудыг ОНХСийн хөрөнгөөр сэргээн засварлана.	40

7	Бэлчээрийн ургамлыг цайвар үлийч оготны хөнөөлөөс хамгаалах ажлыг зохион байгуулах	40,0 мянган га бэлчээрийн талбайн ургамлын цайвар үлийч оготны хөнөөлөөс хамгаалах ажлыг аймгийн дунджаар 86,8 хувийн үр дүнтэй гүйцэтгэсэн.	50,0 мянган га бэлчээрийн талбайн ургамлыг цайвар үлийч оготны хөнөөлөөс хамгаалж бэлчээрийн даац багтаамжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан байна.	Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй 2018 онд “Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, царцааны тархалт, хөнөөлийн тодотгох судалгаа хийлгэх тухай” хамтран ажиллах гэрээний дагуу бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн тархалт, олшролыг тодотгох судалдгааны ажлыг хүрээлэнгийн судлаачид тус аймгийн 7 суманд хийж гүйцэтгэсэн. Судалгааны дүнгээр бэлчээрийн хөнөөлт мэрэгч болох цайвар үлийчийн голомт бүх сумдад тархсан нягтрал хэт олшролын шатандаа орсон энэ үед бэлчээрийн ургамлын 40-өөс дээш хувийг хөнөөдөг байна. Иймээс механик биологийн аргыг микробиологийн аргатай хослон хэрэглэх шаардлагатай байна гэж үзсэн. 2018 онд сумдаас ирүүлсэн судалгаагаар нийт нутаг дэвсгэрийн 17.8 хувь буюу 12 сумын 1503402 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготно тархалттай байна гэсэн судалгаа гарсан. ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын тушаал гарч Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50,0 мян/ га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар тэмцэх шийдвэр гаргасны дагуу аймгийн Засаг даргын захирамж гарч үлийн цагаан оготны голомт бүхий 8 сумын 72,5 мян/га талбайд тэмцэх ажлыг энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэж эхлээд байна. Энэ ажлын хүрээнд аймгийн ОНХСанд тусгасан 36,3 сая төгрөгөөр 10 тн бактержуулсан бэлдмэлийг “ШИМ” ХХК –тай гэрээ байгуулан аймгийн ХХААГ-т хүлээн авч оготны голомт бүхий Өвөрхангай, Төв аймгийн хил залгаа 7 сумын ХАА мэргэжилтэн, байгал орчны байцаагч, багийн засаг дарга, малчин нийт 47 хүнд энгийн механик аргаар хэрхэн тэмцэх болон микробиологийн бэлдмэлийг хэрэглэх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг мөрдөх талаарх чиглэл мэдээллийг өгсөн. Мөн сумдад хяналт тавьж үйл ажиллагааг орон даяар сурталчлан танилцуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50,0 мян/га бэлчээрийн талбайд энгийн механик	70
---	--	--	---	---	----

				аргаар тэмцэх ажлын хүрээнд цөмлөгч-15ш, утагч-40ш багажийг захиалан авчирч сумдад олгосон.	
8	Монгол улсын Засгийн газраас Мах- сүүний анхдугаар аяныг зарласантай холбогдуулан Малын чанар сайжруулах ажлын хүрээнд хэрэгжүүлж буй Эрүүл малд зохиомол хээлтүүлгийн ажлын эрчимжүүлэх аян-ыг зохион байгуулах зорилгоор орон нутагт үхэр сүргийг сүү, мах, мах-сүүний, хосолмол ашиг шимт хээлтүүлэгч малын гүн хөлдөөсөн үрээр зохиомлоор хээлтүүлэх ажлыг эрчимжүүлэх.	Тухайн ажил хийгдээгүй.	Эрчимжсэн аж ахуй гэгдэх сүүний, мах, мах-сүүний хосоломол ашиг шимт үүлдрийн малыг үхэр сүргийн 5% зохиомол хээлтүүлэгт хамруулсан байна.	Хугацаа болоогүй	-
9	Үржилд ашиглаж байгаа хээлтүүлэгч, цөм сүргийн малд үзлэг ангилалт хийж анги чанарыг тогтоох, дутагдаж буй хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавих, баталгаажуулах ажлыг зохион байгуулах.	2017 онд 10500 толгой малд үзлэг ангилалтын ажлыг хийж цөм сүрэгт 7248 толгой мал бүртгэгдээд байна.	Нутгийн шилмэл 15000 хонь, 10350 адуу болон тэмээ нийт 25350 мал үзлэг ангилалтын ажлыг зохион байгуулсан байна.	Аймгийн засаг дарга, ХХААХҮСайдтай 2018 онд хамтран ажиллах гэрээний 9-р заалт, МЭҮГазрын даргын А/18-тоот тушаалын дагуу Хулд сумын 2000 тэмээ, Өндөршил сумын 2500 адуунд үзлэг ангилалтыг хийж гүйцэтгэсэн. Одоо Сайнцагаан сумын 8000 хонин сүрэгт үзлэг ангилалтыг хийж гүйцэтгэж байна.	70
10	50,0 мянган толгой мал тутамд Мал үржүүлэг, технологийн мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн	Одоогийн байдлаар 5 мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний нэгж үйл ажиллагаа явуулж байна.	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж шинээр 10 байгуулсан байна.	Хугацаа болоогүй	-

	нэгжийг сумдад байгуулахад бодлогоор дэмжиж, Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах.				
11	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлыг аймгийн түвшинд зохион байгуулах.	Улсын хэмжээнд нийт бог малын хээлтүүлэгчийн 74,6 % буюу 235,7 мян.тол хуц, ухныг хээлтүүлгийн бус үед эх сүргээс тусгаарлан гэрээгээр маллуулж байна.	Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж буй хуц, ухныг үзлэг, ангилалтанд бүрэн хамруулж, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах	Бог малын хээлтүүлэгчийг Говь-Угтаал сум, Хулд сумдын МҮҮНэгжүүд ялган суурилаад байна. Гэсэн хэдий ч бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед эх сүргээс нь ялгах ажил орон нутагт 50 орчим хувьтай явагдаж байна. Өвөл хавартаа цаг хүнд байсан тул айлууд отор нүүдэл их хийж нутагтаа байран суурин байх нөхцөлгүй байна.	40
12	Малзүйч мэргэжилтнийг бэлтгэх, дунд мэргэжлийн малзүүдэд бакалаврын боловсрол олгох, давтан сургах ажлыг орон нутгийн захиалгаар гүйцэтгэх.	2010-2016 онд малзүйч мэргэжлээр 377 мэргэжилтэн төгссөн бөгөөд үүний 45%-нь тодорхой эрхэлсэн ажилгүй байна. 2017 онд мал зүйч мэргэжлээр 96 оюутан шинээр элсээд байна.	Сум бүрт 1 мэргэжилтэнг орон нутгийн захиалгаар сургасан байна.	Хугацаа болоогүй	-
13	Үржлийн ажлын ололтыг хянан магадлах, баталгаажуулах.	Сайнцагаан суманд үржүүлж буй нутгийн шилмэл хонь, Өндөршил суманд үржүүлж буй нутгийн адуу, Хулд суманд үржүүлж буй Олдохын хоолойн тэмээнд генетикийн шинжилгээг ШУА-ийн Сорилын биологийн хүрээлэнд хийлгэсэн.	Журмын дагуу хянан магадлагаа хийж баталгаажуулсан байна.	МАЗШХүрээлэнтэй хамтран Сайнцагаан сумын Сайнцагаан хонийг омог болгох арга зүйг батлуулан гэрээг байгуулж судалгааны ажлыг хийж байна.	40
14	Үржилд ашиглаж буй	Дэлхийн банкны	Үржилд ашиглаж буй		

	хуц, ухна, бухыг удам зүйн үнэлгээний нэгдсэн программд бүртгэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах.	санхүүжилтээр Малын удам зүйн үнэлгээний программыг боловсруулаад байна.	бух, хуц, ухныг үржлийн үнэт чанараар шалгаруулан үнэлсэн байна.	Хугацаа болоогүй	-
15	Үржилд ашиглаж буй хээлтүүлэгч болон цөм сүргийн малыг дахин давтагдашгүй хувийн дугаараар ялган тэмдэгжүүлж Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах.	Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 63,2 мянган мал бүртгэгдсэнээс үхэр 16,3 мянга, хонь 33,4 мянга, ямаа 13,3 мянган мал бүртгэгдсэн байна.	Бог малын хээлтүүлэгчийг 100%, бод малын хээлтүүлэгчийг 50% хүртэл эзэмжлэж бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах ажлыг зохион байгуулсан байна.	Нийт 109000 мянган мал байгаагаас 90 мянган малыг хувийн дугаартай болгож малыг бүртгэл мэдээллийн сан сүлжээнд хамруулаад байна. Бүртгэл мэдээллийн санд орсноор гарал үүсэл нь тодорхой болж нөхцөл нь бүрдэж байгаа	70
16	ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч хоршоодыг биржийн арилжаанд оруулах талаар Хөдөө аж ахуйн биржтэй хамтарч ажиллах	ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч хоршоодыг биржийн арилжаанд оруулах ажил хангалтгүй хийгдэж байна.	2-оос доошгүй хоршоодыг биржийн арилжаанд оруулах	Гурвансайхан сумын Давших зам хоршоо, Өлзийт сумын Рашаантын аж богд хоршоо, Адаацаг сумын Амьдралын туг хоршоод нь Хөдөө аж ахуйн биржийн Итгэмжлэгдсэн хоршоогоор бүртгэгдэж 3 жилийн хугацаатай Хөдөө аж ахуйн гаралтай, түүхий эдийн арилжаанд оролцох эрхтэй болсон.	100
МАЛ ЭМНЭЛГИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР					
17	Засгийн газрын 2017 оны 248 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тухайн аймагтаа малын гоц халдварт өвчнөөс эрүүл тусгаарлагдсан бүс байгуулах бэлчээр, тэжээлийн газрыг шийдвэрлэх, холбогдох байгууллалуудтай хамтарч ажиллах.	2017 оны 09 сарын 27-ны өдрийн 284 дүгээр тогтоол гарсан. Тогтоол аймагт хүргэгдсэн. Судалгааны ажил эхэлсэн байгаа.	Тухайн аймагт экспортын зориулалттай мал мах бэлтгэх хорио цээрийн тусгаарлагдсан бүс 1-2-ыг бий болгосон байна.	Малын гоц халдварт өвчингүй, эрүүл урьдчилан сэргийлэх вакцин таригдаагүй Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрхангай Хулд, Луус /5/ сумын бог малыг амьдаар гаргах, бүх төрлийн малыг бэлтгэж мах экспортлох талаар судалгаа хийж байна. Хорио цээрийн тусгаарлах бүс байгуулах талаар аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчаас санал, санаачилга гаргаагүй.	40
18	Бог малын мялзан өвчний тандалт	Тандалтаар халдвар илрээгүй	Халдвар гарсан тохиолдолд эрт илрүүлсэн байх	Бог малын мялзан өвчний тандалт шинжилгээг сонгогдсон 5 суманд хийж үр дүнг гаргаж байна.	70

19	Шүлхий өвчний тандалт	Тандалтаар халдвар илрээгүй	Халдвар илрээгүй байх	Шүлхий өвчний тандалт шинжилгээг сонгогдсон 5 суманд хийж үр дүнг гаргаж байна.	70
20	Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалт	Эрсдэлтэй хэсгийг 100% вакцинжуулсан	Халдвар бүртгэгдээгүй байх	Шүлхий өвчнөөс сэргийлэх тарилгыг 12 сумын 30 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж 1 -3 сард 11997 тэмээ, 64416 үхэр, 207890 бог , бүгд 284303 толгой малыг вакцинжуулж шүлхий өвчний тархалтыг таслан зогсоосон. Харин 4 - 5 сард 9 сумын 25344 үхэр, 630821 бог, бүгд 656135 толгой, 2 удаагийн вакцинжуулалтаар нийт 940468 толгой малыг дархлаажуулсан.	100
21	Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын дараах мониторинг	Хамрагдалт хангалтгүй	100% хамруулсан байх	Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын дараах мониторинг 3-р улиралд хийнэ./ Хугацаа болоогүй /.	-
22	Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулалт	Хяналтанд авсан	Шинэ голомт бүртгэгдээгүй байх	Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтыг энэ жил хийхгүй, уг өвчнийг хяналтандаа авсан, вакцины дархлаа хадгалагдаж байгаа.	100
23	Хяналтын цэг ажиллах	Сайнцагаан сум Аривжих гол, Дэлгэрцогт сум Уст хар толгой-д түр хугацаагаар МЭХЦэг ажиллаж байгаа	Түр ажиллагаатай цэг аиллаж байгаа	Сайнцагаан сум Аривжих гол, Дэлгэрцогт сум Уст хар толгой-д 2 сарын хугацаанд хяналтын цэг ажиллуулж малын шилжилт хөдөлгөөн, мах, түүхий эдийн тээвэрлэлтэнд хяналт шалгалт хийж бүртгэлжүүлэх, гарал үүслийн тогтоох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.	100
24	Мал, амьтны архаг халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 нэр төрлийн вакцинжуулалтад бод 47,3 мянга, бог 624,0 мянган толгойг тус тус хамруулах	Аймгийн захиалгын дагуу жил бүр тогтмол хийдэг. Жилээс жилд орон нутгийн төсөв буурч байгаа	Мал, амьтны архаг халдварт зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 нэр төрлийн вакцинжуулалтанд бод 47,3 мянга, бог 624,0 мянган толгойг тус тус хамруулсан байна.	Мал, амьтны архаг халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 нэр төрлийн вакциныг Биокомбинатаас хүлээн авч сумдын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон. Халдварт шөвөг яр өвчнөөс сэргийлэх тарилгын 432.0 мянга малд хийсэн. Вакцинжуулалтын график, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.	70
25	Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд охин тугал 9,3 мянга, охин хурга 353,4 мянга, охин ишиг 326,6 мянга, нийт 689,3 мянган толгой төл мал	Өнгөрсөн онд охин тугал, хурга, ишгийг хүйс харгалзахгүй вакцинжуулж байсан.	Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд охин тугал 9,3 мянга, охин хурга 353,4 мянга, охин ишиг 326,5 мянга, нийт 689,3 мянган толгой төл мал хамруулсан	Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт 3-р улиралд хийгдэнэ. /Хугацаа болоогүй /	-

	хамруулах.		байна.		
26	Буур, бух, хуц, ухна нийлсэн нийт 17,901 толгой хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний шинжилгээг хийж, эерэг буюу өвчтэй гарсан хээлтүүлэгчийг засах, хөнгөлөх аргаар үржлээс хасч халдвар дамжуулах эрсдэлийг бууруулах.	Улсын төсвөөр нэгдсэн тандалт хийж байгаагүй. Орон нутгийн төсвөөр тодорхой тооны малд хийсэн.	Буур, бух, хуц, ухна нийлсэн нийт 17,901 хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний шинжилгээг хийж эерэг буюу өвчтэй гарсан хээлтүүлэгчийг засах, хөнгөлөх аргаар үржлээс хасч халдвар дамжуулах эрсдэлийг бууруулсан байна.	Бруцеллёзын хээлтүүлэгчийн шинжилгээ 3-р улиралд хийгдэнэ. / Хугацаа болоогүй /	-
27	Мал, амьтны өвчний тандалт шинжилгээний ажлын гүйцэтгэлийн үр дүнд тавих дотоод хяналтыг сайжруулах	Үйл ажиллагаа хэвшээгүй	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Мал, амьтны өвчний тандалт шинжилгээний ажлын гүйцэтгэлд байгууллагын удирдлага, санхүүгийн талаас тавих хяналтыг сайжруулж зардал үр дүнг холбон тооцдог болсон.	70
28	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулах, хэрэгжилтэнд тавих дотоод хяналтыг сайжруулах.	Үйл ажиллагаа тогтмол биш	Хэвшсэн байна.	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэнд тавих хяналтын зардлыг суулган ажлын хэсгүүд гарч газар дээр нь очиж үзлэг шалгалт хийлээ. Аймгийн Засаг даргын захирамжаар вакцинажуулалтын явцад хяналт тавих ажлыг Онцгой комиссын гишүүдэд даалгасны дагуу сумдад ажиллаж хяналт тавьж, заавар зөвлөмж өгсөн.	70
29	Мэл эмнэлгийн графикт болон өдөр тутмын мэдээний программ хангамжийг ашиглан мэдээ мэдээллийг цахимаар хугацаанд нь бүрэн мэдээлж хэвшүүлэх	Үйл ажиллагаа тогтмол биш	Хэвшсэн байна.	Мал эмнэлгийн мэдээ, тайланг шуурхай болгохоор интернетэд суурилсан бүртгэл мэдээлэлийн программ нэвтрүүлж, мэдээ, мэдээлэлийг цахимаар хугацаанд шуурхай гаргаж байна	100
30	Орон нутгийн түвшинд мал, амьтны гоц халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлсийн судалгааг	Судалгаа сайн хийгдээгүй	Өвчний эрсдэл буурсан байна.	Мал амьтны гоц халдварт өвчний судалгааг жил бүр гаргаж үйл ажиллагаандаа ашигладаг. Эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж судалгаа гаргасан мөн гамшгийн төлөвлөгөө гарган батлуулсан. Үүндээ гоц халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгааг	70

	хийх, түүнд үндэслэн эрсдэлийг бууруулах			оруулсан.	
31	Орон нутгийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн болон тасгийн малын эмч нарыг мэргэшүүлэх, гоц халдварт өвчний давтан сургалтанд хамруулах	Сургалтанд бүрэн хамруулаагүй	Сургалтанд хамруулах хүний тоо	Орон нутгийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн болон тасгийн малын эмч нарыг мэргэшүүлэх, гоц халдварт өвчний давтан сургалтанд хамруулах арга хэмжээ 3,4-р улиралд хийгдэнэ. Хугацаа болоогүй/	-
32	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, малын генетик нөөцийн тухай хуулийг сурталчлах.	Хууль шинээр батлагдсан	Сурталчилсан байна.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, малын генетик нөөцийн тухай хуулийг аймгийн ХАА-н салбарын мэргэжилтний зөвлөгөөн, сумдад болж байгаа малчдын зөвлөгөөнүүдэд ярьж танилцуулсан. АСЦ FM -ээр малчид зориулан хуулийн мэдээлэл 3 удаа явуулсан.	70
33	Аймгийн мал эмнэлгийн газрын хөрөнгө салгах бэлтгэл хангах	Мал эмнэлгийн газар шинээр байгуулагдах болсон	Бэлтгэл хангаж ажилласан байх	Бэлтгэлийг ханган ажиллаж байна.	70
34	Аймаг, сумдын мал эмнэлгийн төрийн албанд ажиллах мэргэжилтнүүдийн судалгаа гаргах	Судалгаа гаргаагүй	Судалгааг гаргасан байна.	Аймаг, сумдын мал эмнэлгийн төрийн албанд ажиллах мэргэжилтнүүдийн судалгааг гарган МЭҮГ-т хүргүүлсэн.	70
35	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлыг 2-оос доошгүй суманд зохион байгуулах туршиж хэрэгжүүлэх.	Орон нутагт хувийн аж ахуйн нэгжүүдийн хийсэн төлөвлөгөө төсөл байгаа	2-оос доошгүй суманд үржлийн ажил үйлчилгээний нэгж бий болж хээлтүүлэгчээ ялган төвлөрүүлсэн байна.	Бог малын хээлтүүлэгчийг Говь-Угтаал сум, Хулд сумдын МҮҮНэгжүүд ялган суурилаад байна.	100
ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР					
36	Тариалангийн тухай хуулийг сурталчилан таниулах	Сурталчилгаа сайн хийгдэхгүй байгаа	Сурталчилсан байна	“Тариалангийн тухай хуулийг сурталчилан таниулах” тухай МЭҮТасгийн 15 мэргэжилтэнүүд болон АС цогцолбор мэдээ мэдээлэл хийсэн.	70
37	Тариалангийн талбайд	Мэдээллийн сан	Мэдээллийн сан	Хугацаа болоогүй.	-

	мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учруулсан хохирлыг тооцох аргачлалыг сумын түвшинд танилцуулах, энэ чиглэлээр сургалт зохин байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, мэдээллийн сан үүсгэх.	байхгүй	үүсгэсэн байх		
38	Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын үзүүлэлтийг тогтоох хөрсний агрохими, агрофизикийн шинжилгээг хийлгэж байгаа эсэхэд хяналт тавих, шинжилгээний дүнгээр мэдээллийн сан үүсгэх.	Мэдээллийн сан үүсгэх	Мэдээллийн сан үүсгэсэн байх	Талбайн хөрсийг шинжилгээнд хамруулсанаар хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлээс хамгаалах арга хэмжээг оновчтой зөв авч хэрэгжүүлэх, бордоог зөв тооцоолж бордохоос гадна хөрсний үржил шим сайжирч бүтээгдэхүүний чанар сайжрах талаархи мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Говийн нөхцөлд мэдээллийн сан үүсгэх боломжгүй.	70
39	Засгийн газрын 2017 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан Жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд Жимс жимсгэнэ дэд хөтөлбөр боловсруулж батлуулан хэрэгжүүлэх.	2017 оны байдлаар улсын хэмжээгээр 6300 га тайлбайд жимс жимсгэнэ тариалж байгаа ба 2700 орчим тонн ургац хураан авч байна.	Жимс жимсгэнэ тариалах ард иргэдэд зааж сургахад орон нутгийн хөрөнгөөр дэмжлэг үзүүлж жимс жимсгэний тариалалтыг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх.	Энэ онд шинээр чацаргана 0,5 га-д 500 ш, Уйлас 0,1 га-д 600 ш тариалаад байна. Жимс жимсгэнэ тариалах ард иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	40
40	Засгийн газрын 223 дугаар тогтоолоор батлагдсан Жимс жимсгэнэ хөтөлбөр, 278 дугаар тогтоолоор батлагдсан Хүнсний ногоо хөтөлбөрийн зохих санхүүжилтийг	Тэжээл 36,6 га-с 5,2 тн, төмс 39 га-с 168 тн, хүнсний ногоо 22,2 га-с 75,9 тн хураасан.	2017 оны түвшингээс буудай 2 хувь, тэжээл, тос 1 хувь, төмс 3 хувь, хүнсний ногоо 5 хувь, жимс жимсгэнэ 10 хувийн өсөлтөөр үйлдвэрлэлийг нэмэгдсэн байна.	Хаврын тариалалтын мэдээг сумдын МЭҮТасгийн мэргэжилтнээс авч ХХААХҮЯамны ГТБХЗГазарт долоо хоног бүрийн 2 дахь, 4 дахь өдрүүдэд мэдээлж байна. Хоцроосон болон тасалсан мэдээ тайлан байхгүй.	40

	орон нутгийн төсөвт тусгуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.				
41	Аймгийн хүн амын өсөлт, хэрэгцээнд үндэслэн буудай, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах газрыг судалж тариалалт ургацыг нэмэгдүүлэхэд орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллан шийдвэрлүүлэх.	Орон нутагт төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах газар олгогдохгүй байгаагаас үйлдвэрлэл өсөхгүй байгаа.	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах хуулийн этгээд, иргэдэд газар шинээр олгож үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ахиц гарсан байх.	Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажилгүй иргэдийг ажлын байраар хангах хөтөлбөрийн хүрээнд 30 иргэнийг 3 бүлэгт хуваан 1 га газар болон 152 м.кв хүлэмж, үр, бордоо, тоног төхөөрөмжийг нийлүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	70
42	Ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүнд батлагдсан гарал үүслийн гэрчилгээ олголтонд хяналт тавьж тайлагнах.	2015 онд журам батлагдсан ба хэрэгжилт хангалтгүй байна.	Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж зах зээлд борлуулагдаж буй дотоодын ургацын дүн мэдээ нь бодлого төлөвлөлтөнд нөлөөлсөн байна.	Хугацаа болоогүй	-
43	Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний техник усалгааны тоног төхөөрөмж, нийлэг хальсан хүлэмж, үр суулгац, бордоо, ургамал хамгааллын бодис захиалгаар нийлүүлэхэд олон нийтэд мэдээлж хамтран ажиллах.	Хүнсний ногоо, жимс жимсгэнэ хөтөлбөр батлагдсантай холбоотой нийлүүлэгдэх үр, бордоо, техник төхөөрөмжүүд нийлүүлэгдэх болсон.	Захиалга хэрэгцээнд тулгуурлан Сайдын тушаалаар батлагдсан хувиараар техник, усалгааны тоног төхөөрөмж, үр суулгац, бордоо, ургамал хамгааллын бодис нийлүүлэгдсэн байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хүнсний ногооны үр олголоо. “ Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сонгино, шар манжин, шар лууван, хүрэн манжин, сармис, урт сонгино, гоньд, өргөст хэмх, амтат гуа зэрэг 14 нэр төрлийн 6653700 /зургаан сая зургаан зуун тавин гурван мянга долоон зуун төгрөг/-н үнэ бүхий хүнсний ногооны үрийг манай аймагт хуваарилсныг хүлээн авч 15 сумын өрхийн хүнсний ногоо тариаланчдад үнэ төлбөргүй олгож дэмжлэг үзүүллээ.	70
44	Газар тариалангийн холбогдолтой графикт болон цаг үеийн	Цаг үеийн яаралтай үед утас холбогддоггүй.	Мэдээ мэдээлэл, тайлан хугацаандаа үнэн зөв гаргагдаж	Цаг үеийн болон салбарын холбогдолтой бусад мэдээллийг хуваарьт хугацаанд гарган хүргүүлэн ажиллаж байна. Гаргаагүй хугацаа хожимдсон	70

	яаралтай мэдээ, тайланг маягт зааврын дагуу хугацаанд нь ирүүлэхэд онцгойлог анхаарах.	Мэргэжилтэн нарын утас байн, байн солигддог үүнийг анхаарах.	УИХ,ЗГ яамдуудад тайлагнасан байх	мэдээ тайлан байхгүй.																																					
45	Урьд жилүүдийн өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах	Техник, хүлэмж, усалгааны тоног төхөөрөмж, үр бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийн өр авлага тухайн жилдээ гэрээний дагуу барагдуулдаггүй орхигдуулдаг.	Өр авлага багассан байна.	1 аж ахуйн нэгж, 10 иргэний өр авлагыг барагдуулах талаар албан тоотыг хүргүүлээд байна.	40																																				
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР																																									
46	21 Аймгийн үйлдвэржилтийн өнөөгийн байдал суурь	Хангалтгүй	Түүхий эдийн үнийн мэдээлэлтэй болно	Малын гаралтай түүхий эдийн үнийн мэдээг сар бүр батлагдсан маягтын дагуу гарган Хөнгөн үйлдвэрийн газрын мэргэжилтэн Д.Амаржаргалын amarjargald@mofa.gov.mn хаягаар хүргүүлж байна.	70																																				
				<table><tr><td>№</td><td>Түүхий эдийн нэр</td><td>Жилийн дундаж үнэ</td></tr><tr><td>1</td><td>Адууны шир</td><td>5,000</td></tr><tr><td>2</td><td>-2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир</td><td>6,250</td></tr><tr><td>3</td><td>-2 м-ээс дээш хэмжээтэй үхрийн шир</td><td>5,000</td></tr><tr><td>4</td><td>Хонины нэхий өлөнтэй</td><td>1,625</td></tr><tr><td>5</td><td>Хонины нэхий өлөнгүй</td><td>-</td></tr><tr><td>6</td><td>Ямааны арьс</td><td>9,250</td></tr><tr><td>7</td><td>Тэмээний шир</td><td>1,500</td></tr><tr><td>8</td><td>Хонины ноос</td><td>-</td></tr><tr><td>9</td><td>Ямааны ноолуур</td><td>26,500</td></tr><tr><td>10</td><td>Тэмээний ноос</td><td>-</td></tr><tr><td>11</td><td>Сарлагийн хөөвөр</td><td>-</td></tr></table>		№	Түүхий эдийн нэр	Жилийн дундаж үнэ	1	Адууны шир	5,000	2	-2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир	6,250	3	-2 м-ээс дээш хэмжээтэй үхрийн шир	5,000	4	Хонины нэхий өлөнтэй	1,625	5	Хонины нэхий өлөнгүй	-	6	Ямааны арьс	9,250	7	Тэмээний шир	1,500	8	Хонины ноос	-	9	Ямааны ноолуур	26,500	10	Тэмээний ноос	-	11	Сарлагийн хөөвөр	-
				№		Түүхий эдийн нэр	Жилийн дундаж үнэ																																		
				1		Адууны шир	5,000																																		
				2		-2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир	6,250																																		
				3		-2 м-ээс дээш хэмжээтэй үхрийн шир	5,000																																		
				4		Хонины нэхий өлөнтэй	1,625																																		
				5		Хонины нэхий өлөнгүй	-																																		
				6		Ямааны арьс	9,250																																		
				7		Тэмээний шир	1,500																																		
				8		Хонины ноос	-																																		
				9		Ямааны ноолуур	26,500																																		
				10		Тэмээний ноос	-																																		
11	Сарлагийн хөөвөр	-																																							

47	21 аймгийн үйлдвэржилтийн өнөөгийн байдал суурь судалгааны үйлдвэрлэлийн хүчин чадал, ашиглалтын хувь тодорхой болгох.	Одоогоор үйлдвэрлэлийн мэдээлэл ирүүлдэгч ихэнх аймгууд суурь судалгаанд шинэчлэл хийх шаардлагатай. Ажилдаггүй үйлдвэрийг хасах ажиллаж байгаа үйлдвэрүүдийг нэмэх, суурь хүчин чадал ашиглалтын хувь тодорхой болох	Орон нутгийн үйлдвэрүүдийн хүчин чадлыг бүрэн тодорхойлсон мэдээ мэдээллийг үнэн бодит болгосон байна.	Аймгийн хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 79 үйлдвэр аж ахуйн нэгж байна. Үйлдвэрүүд нь нийт суурь хүчин чадалынхаа 69,7 хувийг ашиглаж байна. 2017 онд 2,392,55 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан байна.	100
48	Түүхий эд бэлтгэлийн /ноос, ноолуур, арьс шир/, сургалт, семинар зохион байгуулах	Аймгуудад арьс, шир 30%, ноос ноолуур төслийн хүрээнд сургалт явуулсан.	Малчдыг чадавхижуулнэ. Түүхий эдийн үнэ цэнэ өснө.	Хугацаа болоогүй	-
49	Аймаг орон нутгийн онцлогтой хоол ундааг бий болгох, сурталчлан таниулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тайлагнах.	Үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол ундааг хөгжүүлэх нь сэдэвт бүсийн аварга тогооч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан, сургалт, спортын арга хэмжээ зохион байгуулагдсан.	Аймгийн хэмжээнд орон нутгийн онцлогтой хоол, ундааг сурталчлах ажлыг 2-оос доошгүй удаа хийсэн байна.	Хугацаа болоогүй	-
50	Цэцэрлэг, сургуулийн хүнсний хангамжийн үйл ажиллагааг сайжруулах, оновчтой зохион байгуулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж үр дүнг тайлагнах.	Аймгийн ХХААГазрын мэргэжилтнүүдийн оролцоо хангалтгүй, ЗДТГ, Боловсролын газартай хамтарч ажиллах шаардлагатай.	Холбогдох байгууллагуудтай хамтран 2-оос доошгүй ажил зохион байгуулсан байна.	Стандарт хэмжил зүйн хэлтэс Сайнцагаан сумтай хамтран аймгийн төвийн сургууль цэцэрлэгийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэлтийн байдалтай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Сургууль, цэцэрлэгүүд нь хүнсний худалдаа эрхлэгчтэндэрт шалгарсан 8 ААНэгж 7 иргэнтэй шууд гэрээ байгуулан ажиллаж байна	40
51	Явуулын ахуй үйлчилгээг сумдын түвшинд зохион	Ахуй үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд 2012-2014 онд сумдад	Явуулын үйлчилгээг 2 удаа зохион байгуулсан байна.	Хугацаа болоогүй	-

	байгуулан ажиллаж үр дүнг тайлагнах.	явуулын ахуй үйлчилгээг зохион байгуулж байсан.			
ХҮНСНИЙ САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР					
52	Мах сүүний анхдугаар аяныг нутаг дэвсгэртээ зохион байгуулах.	Мах сүүний анхдугаар аяныг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан.	2018 онд хийгдэх ажлууд бүрэн хийгдсэн байна.	Мах сүүний анхдугаар аяныг нутаг дэвсгэртээ зохион байгуулах ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөг ЗДТГ-ын ХОХБТ-ийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70
53	Орон нутагтаа үйлдвэрлэсэн ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулж гэрчилгээ олгох мэдээллийн сан үүсгэх.	Мэдээллийн сан байхгүй.	Мэдээллийн сан үүсгэсэн байх.	Хугацаа болоогүй	-
54	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх судалгаа, тооцоолол хийх	Судалгаа тооцоолол муу хийгддэг.	Судалгаа тооцоолол хийгдсэн байна.	10 мянган хүний 100 хоногт хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний тооцоо, “Өнө мөнх Хайрхан”, “Номгон Рашаан” ХХК-ны агуулахад байгаа гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний судалгаа, тооцооллыг хийж ХХААХҮЯаманд хугацаанд хүргүүлсэн.	100
55	Сав баглаа боодол хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж 2018 оны төсөвт санхүүжилийг тусгах	Төлөвлөгөө байхгүй	Төлөвлөгөөг баталсан байна	Хугацаа болоогүй	-
56	Хэрэглэгчийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан Хүнсний аюулгүй байдал мэдээллийн	Салбарын сурталчилгаа сайн хийгдэхгүй байгаа.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сайнцагаан сумтай хамтран Сүүн Цагаан Сайнцагаан сонинд “Хүнсний аюулгүй байдлын булан нээж сар бүр хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээ зөвлөмжийг бэлтгэн хэрэглэгчидэд хүргэж ажиллаж байна.	100

	цаг, булан ажиллуулах.				
57	Мах сүүний анхдугаар аяныг зохион байгуулах арга хэмжээний 4-р зорилт, 33-р заалтыг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн нөөцийг ашиглах, сүүг эдийн засгийн эргэлтэнд оруулах Монгол хуурай сүү төслийг хамтран хэрэгжүүлэх.	2017 онд Хөвсгөл аймгийн Их-уул суманд хуурай сүүний үйлдвэр байгуулсан.	Өлзийт суманд хуурай сүүний жижиг оврын үйлдвэр байгуулагдсан байна.	Бага оврын хуурай сүүний үйлдвэрийн барилга барихад шааардлагатай 64 сая төгрөгийн төсөв бүхий ТЭЗҮ-г ХХААХҮЯаманд хүргүүлсэн.	40
58	Хүнсний тухай хуулийн 6.1, 6.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг тухай бүр холбогдох мэдээ мэдээллээр ханган хамтран ажиллах.	Стратегийн хүнс-мах, сүү, гурилаар тогтвортой хангах, улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах талаар журам байхгүй байна.	Журмыг боловсруулж аймаг орон нутагт сургалт зохион байгуулагдсан байна.	Хугацаа болоогүй.	-
59	Хүнсэнд бэлтгэх малын тоо хэмжээг малын төрөл тус бүрээр 2018 оны 2 дугаар улиралд багтаан урьдчилсан байдлаар тооцон гаргаж ирүүлэх.	2017 оны Аймгийн засаг дарга, ХХААГазрын дарга нартай байгуулсан гэрээнд тусгасан боловч биелэлт ирүүлээгүй.	Заасан хугацаанд ирүүлж байх.	Хүнсэнд бэлтгэх малын тоог урьдчилсан байдлаар малын төрөл тус бүрээр тооцож гаргалаа Үүнд: тэмээ 848, адуу 4071, үхэр 4173, хонь 90747, ямаа 94225 нийт 194065 толгой мал хүнсэнд нийлүүлэх судалгаа байна.	100
60	Хүнсэнд хэрэгцээлсэн малын тоо хэмжээг 2018 оны 11 сарын 30-ны байдлаар гаргаж тайлан ирүүлэх. Мал төхөөрөн үйлдвэрт нийлүүлсэн болон	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ 22.0 мян.тн	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ нэмэгдэж 30.0 мян.тн хүрэх.	Хугацаа болоогүй.	-

	уламжлалт аргаар бэлтгэсэн малын тоогоор тооцож гаргах				
61	Газар тариалан, мал аж ахуй, зөгийн органик үйлдвэрлэл эрхлэх журмыг сурталчлах, органик хүнс үйлдвэрлэлд шилжих үндсэн зарчим, арга технологийн талаар ХАА-н анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч- малчид, тариаланчдад мэдлэг олгох ажлыг зохион байгуулах.	Оролцооны баталгаажуулалт болон органик ХХАА-н олон улсын сургалтыг бүх аймгийн ХХААГазрын хүнсний мэргэжилтнүүдийг хамруулан 2016 оны 10 сар болон 2017 оны 11 сард тус тус зохион байгуулсан.	Органик хүнс үйлдвэрлэлд шилжих үндсэн зарчим, арга технологийн талаар ХАА-н анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч- малчид, тариаланчдын дунд сургалт, сурталчилгааг 1-2 удаа хийсэн байх.	“Эрүүл мал эрсдэлгүй бүтээгдэхүүн сарын аяны хүрээнд” ХАА-н анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчдэд хандсан сурталчилгааг /шторк/ МХГазартай хамтран бэлтгэж байгууллагын Face групп, Сайнцагаан сумын сургууль цэцэрлэгүүдэд сүү нийлүүлдэг фермер эрхлэгч 5 иргэнд “Органик хүнс үйлдвэрлэлд шилжих арга”-ын талаарх сургалт зөвлөгөөг өгч ажиллалаа.	100
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШООНЫ БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР					
62	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг шийдвэрлэх.	2014 оноос хойш санхүүжилт хийгдээгүй	Хүн амын тооноос хамааруулан эх үүсвэр хуваарилж хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлсэн байна.	Энэ онд Аймгийн дэд хороонд зээлийн санхүүжилт хийгдээгүй. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн бодлогын зээлд хамруулахаар Мандалговь хүнс ХХК, Зайрмагтайн булаг ХХК, ТЭББЭ ХХК, Дэрэн-Уул ХХК, Ноён Шанхай ХХК, Монгол Drian Milk ХХК-ийн төслүүдийг хүргүүлсэн. 04 сард болсон ЖДҮХСангийн хорооны хуралаар дэмжигдээгүй. Гэсэн хэдий ч 7 сард зээлийн эргэн төлөлтөөс олгох төсөлд хамруулахаар болсон. СХСангаас Эрдэнэдалай, Хулд сум 16 бизнес эрхлэгчдэд 134,5 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг олгосон. Үүний үр дүнд бүтээгдэхүүний нэр төрөл 4-5 төрлөөр нэмэгдсэн байна. Нийт 19 ажлын байр бий болсон. Үүнээс хадгалагдсан ажлын байр-3, шинэ 16 ажлын байр нэмэгдсэн.	40
63	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрээс чанар, стандартын	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрээс чанар стандартын шаардлага хангасан бараа худалдан авалтыг	Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор баталсан жагсаалтад багтсан бараа ажил үйлчилгээг худалдан авах ажлын хүрээнд Аймгийн засаг даргын захирамж гарган ажиллаж байна. Уг захирамжийн хүрээнд орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг төрийн болон төрийн бус байгууллага нь хэрэгцээнд авч	70

	шаардлага хангасан Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор баталсан жагсаалтад багтсан бараа, ажил үйлчилгээг худалдан авах.	бараа худалдан авалт муу, худалдаж авсан бараа ажил үйлчилгээний талаархи мэдээг хугцаанд нь ирүүлэхгүй байна.	нэмэгдүүлсэн байх. Худалдаж авсан бараа ажил үйлчилгээний талаархи мэдээг хугцаанд нь ирүүлсэн байх.	хэрэглэж хэвшээд байна.	
64	Жижиг, дунд үйлдвэрийн зориулалтаар олгож байгаа зээлийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжилтэнд хяналт тавих, зээлийн талаархи мэдээ тайланг хагас, бүтэн жилээр ирүүлэх.	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сангаас олгож байгаа зээлийн мэдээлэл тогтмолжоогүй.	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд сан болон сум хөгжүүлэх сангийн тайланг хугцаанд нь ирүүлсэн байна.	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан, зээлтэй байгаа, зээлийн үлдэгдэлийн судалгааг гаргасан. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас одоогийн байдлаар 49 зээлдэгч 448,1 сая төгрөгний зээлийн үлдэгдэлтэй байна. 15 сумаас сум хөгжүүлэх сангийн мэдээг нэгтгэн ХХААХҮЯамны Жижиг дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хугцаанд нь хүргүүлсэн.	70
65	Загвар хоршоо байгуулахад анхаарч дэмжлэг үзүүлэх.	Хоршооны зарчмаар гишүүдийн үүсгэл санаачлагаар байгуулагдсан загвар хоршоод байгуулагдаагүй байна.	Загвар хоршоо байгуулах суурь тавигдсан байна.	Эрдэнэдалай сумын Далайн Хөгжил хоршоог Улсын шилдэг хоршоонд нэр дэвшүүлсэн материалыг ЖДҮХБХзохицуулах газарт хүргүүлээд байна.	40
66	Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх.	Түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бүрдээгүй байна. Түүхий эдийн биржийн байнгын бус оролцогч болох хоршоодыг тогтолцоог бүрдүүлэхэд оролцуулах хэрэгтэй байна.	Түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бүрдсэн байна.	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхийн эдийн бэлтгэлийн тогтолцоог сайжруулж, малчид, хоршоог биржийн арилжаанд оролцуулах зорилгоор Дундговь аймгийн мал аж ахуйн болон газар тариалангийн үйл ажиллагааны мэдээлэл, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоо, дундын хоршоо болон агуулахын мэдээлэлийг 2017 оны байдлаар ХАА-н биржид гаргаж өгсөн. Дундговь аймгийн Хөдөө Аж Ахуй Хоршоологчдын Холбооны 13-р бага хурал болж аймгийн Засаг дарга, ХХААГ-ын дарга, Аймгийн ХААХХ-ны дарга, 15 сумын гишүүн хоршоодын төлөөлөгчид болон зарим албаны хүмүүс оролцлоо. Мөн “Могол ноос” ХХК-ны ерөнхий захирал Ч.Эрдэнэбат, Хөдөө аж	70

				ахуйн биржийн Арилжааны хэлтсийн дарга Д.Оюун-Эрдэнэ нар урилгаар хүрэлцэн ирж мэдээлэл хийсэн. Энэ үеэр Гурвансайхан сумын Давших зам хоршоо, Өлзийт сумын Рашаантын аж богд хоршоо, Адаацаг сумын Амьдралын туг хоршоод нь Хөдөө аж ахуйн биржийн Итгэмжлэгдсэн хоршоогоор бүртгэгдэж 3 жилийн хугацаатай Хөдөө аж ахуйн гаралтай, түүхий эдийн арилжаанд оролцох эрхийн гэрчилгээгээ гардан авсан.	
67	Монголд үйлдвэрлэв үзэсгэлэн худалдааг зохион байгуулж хэвших, зардлыг орон нутгийн төсөвт тусгах.	Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэхэд тал бүрийн дэмжлэг туслалцаа шаардлагатай байна.	Монголд үйлдвэрлэв үзэсгэлэн худалдааг зохион байгуулж хэвшсэн байна.	Хугацаа болоогүй	-
68	Гарааны бизнес эрхлэгчийг дэмжих	Гарааны бизнес эрхлэгчийг дэмжих үйл ажиллагаа тодорхойгүй байна	Гарааны бизнесийг дэмжсэн байна.	СХСангаас Эрдэнэдалай, Хулд сум 14 бизнес эрхлэгчдэд 86,5 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг олгосон. Үүний үр дүнд бүтээгдэхүүний нэр төрөл 3-4 төрлөөр нэмэгдсэн байна. Нийт 14 шинэ ажлын байр бий болсон.	40
69	Орон нутгийн бүтээгдэхүүний худалдааны төв, зам дагуу борлуулалтын цэг байгуулахыг дэмжиж ажиллах.	Орон нутгийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх талаар олон төрлийн арга хэмжээ авах хэрэгтэй байна	Орон нутгийн бүтээгдэхүүний борлуулалтын төв, зам дагуу борлуулалтын цэг байгуулсан байна	2017 оноос эхлэн “Дундговьд үйлдвэрлэв” дэлгүүрийг нээн ажиллуулж байна. Дундговьд үйлдвэрлэв дэлгүүр нээгдсэнээр одоогоор борлуулалтын орлого нь 52 сая төгрөг болоод байна. Борлуулалтын орлого сар тутам 1-2 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Уг дэлгүүрээр тогтмол 174 иргэний 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулагдаж байна. Цаашлаад Улаанбаатар хотод Жанжин 25, 21:21 төслүүдтэй холбогдон борлуулалтын сүлжээгээ нэмэгдүүлээд байна.	70
70	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох	Орон нутгийн нөөц, онцлогт тулгуурлан хөгжүүлэх бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхойлоогүй, борлуулалтын сүлжээг бий болгоогүй байна.	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгож, түүнийг хэрэглэгчидэд хүргэх борлуулалтын сүлжээг бий болгосон байна.	Хугацаа болоогүй	-

71	Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг таниулах, сурталчлах, батлан даалтан хамруулах ажлыг эрчимжүүлэх	Зээлийн батлан даалтын үйлчилгээ орон нутагт хангалтгүй байна.	Зээлийн батлан даалтын үйлчилгээнд орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг хамруулсан байна.	4 удаагийн хурал, зөвлөгөөнд нийт 183 иргэнд ЗБДСангийн мэдээлэл өгсөн. Өмнөх онуудад тус аймгаас зээлийн батлан даалтын санд 5 бизнес эрхлэгч зээлтэй байгаа үүнээс 4 бизнес эрхлэгч буюу Дэлгэрэх бүрд ХХК, Мандал Шилтгээн ХХК, М.Цэрэнпагма, Д.Баясгалан нарын үйл ажиллагаатай танилцан мониторинг хийсэн. 2018 оны 2 дугаар улиралд Зээлийн батлан даалтын санд 3 бизнес эрхлэгчийн анхан шатны хүсэлтийг явуулаад байна.	70
72	Аймгийн нийт хоршоодод үнэлгээ хийх	Хоршоодод 2012 онд үнэлгээ хийсэн. Хоршоодын хөгжлийг үнэлэх үнэлгээний шинэ аргачлал боловсруулсан.	Аймгийн нийт хоршоодыг хамруулсан байна	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан хоршоодыг үнэлэх үйл ажиллагааны удирдамжийн дагуу Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа, улсын бүртгэлд бүртгэлтэй нийт 100 хоршоодод үнэлгээ хийх ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундговь аймаг нь нийт Улсын бүртгэлд бүртгэлтэй 100 хоршоотой. Үүнээс 78 хоршоо нь идэвхтэй 21 хоршоо нь цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй татан буулгах хүсэлтэй, зарим нь татан буулгахаар материал бүрдүүлж өгсөн хоршоо байна. Татан буулгах хүсэлтэй байгаа хоршоодод татан буулгахад ямар материал бүрдүүлж өгдөг талаар зөвлөгөөг өгөн ажилласан. Мөн 1 хоршоо нь ААНэгж болсон байна. Үнэлгээг хоршооны засаглал, санхүү, үйлдвэрлэл технологи, маркетинг, гишүүнчлэл гэсэн 5 бүлгийн хүрээнд үнэлэх, хоршоодод нийтлэг тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор асуулга, ярилцлага хийх, баримт бичгүүдтэй танилцах, харьцуулах аргачлалаар хийсэн. Энэхүү үнэлгээнд нийт 78 хоршоо хамрагдав. Хоршоодыг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзэхэд авто засвар, тээврийн үйлчилгээ-3, Газар тариалан-8, Бөөний болон жижиглэн худалдаа-5, Жонш олборлох, худалдан борлуулах-1, Модон эдлэл үйлдвэрлэл-3, Хадгаламж зээлийн хоршоо-6, Ном, сэтгүүл хэвлэл үйлдвэрлэл-2, Ноос, ноолууран	100

			бүтээгдэхүүн үйлдвэрлэл-6, Хөдөө аж ахуй, Мал аж ахуйн чиглэлийн-43, Шатахууны жижиглэн худалдаа-1 хоршоо байна. Хоршоодод явуулсан үнэлгээгээр нийт хоршоодын 9,0 хувь нь (7 хоршоо)тогтвортой өсөлттэй буюу загвар хоршоо, 20.5 хувь нь (16 хоршоо)хөгжиж байгаа, 34,6 хувь нь (27 хоршоо)идэвхижиж байгаа, 35,9 хувь нь (28хоршоо)идэвхигүй гэсэн үнэлгээ тус тус авлаа. Хоршооны үнэлгээний тайланг ХХААХҮЯмны ЖДҮХБЗГазарт хүргүүлсэн.	